

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-19

- 1. Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/** 7-16
 - 2. Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч 4” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/** 16-17
 - 3. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/** 17-19
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
07 дугаар сарын 03-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 33 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Бум-Очир, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Ц.Мөнхбат, Г.Очирбат, Л.Оюун-Эрдэнэ, Б.Тулга;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Болормаа, С.Лүндэг;

Тасалсан: Б.Батбаатар, Л.Гантөмөр, Б.Жаргалан, Ө.Шижир, Р.Эрдэнэбүрэн.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр үг хэлэв.

Нэг.Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн Ерөнхий инженер Д.Чинбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг нар байлцав.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, Ж.Энхбаяр, Г.Хосбаяр, Ч.Анар нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн

хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч 4” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Найдалаа, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн Ерөнхий инженер Д.Чинбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг нар байлцав.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч 4” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ж.Алдаржавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёл, урлагийн бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Наранцэцэг, Хавдар судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал Ц.Батболд, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирал Ж.Отгонбаатар, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн захирал Ж.Галбадрах, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Т.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг нар байлцав.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	7
Бүгд:	16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 51 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Ирцийг танилцуулъя.

Очирбатын Амгаланбаатар, Чинбаатарын Анар, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Хажикберын Жангабыл гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Жадамбаагийн Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Өнөөдөр хэлэлцэх 3 асуудал байгаа. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээр асуудал. Монгол Улс Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн 3 дугаар үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл байгаа. Засгийн газар 07 сарын 02-нд өргөн мэдүүлсэн, соёрхон батлах асуудал.

2 дугаарт Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч 4” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

3-д Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслүүд байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Хосбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ Сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийг дэмжиж байгаа. Яагаад вэ гэхээр манай Өвөрхангай аймаг, Архангай аймаг, Баянхонгор аймаг бол хангайн бүс. Эрчим хүчээ Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх шугамаар авдаг. Тэгэнгүүт 1 эх үүсвэртэй. Тэгээд та бүхэн санаж байгаа бол 3, 4 жилийн өмнө Булган аймагт 1 усан шуурга болоод Булганы Дашинчилэнд өндөр хүчдэлийн шонгууд унахад Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймаг бүтэн 7 хоног зун тоггүй байсан. Тэгээд энэ төсөл хэрэгжсэнээр бол Мандалговь, Арвайхээр чиглэлийн 220квт-ын хос ЦДАШ баригдах юм байна лээ.

Тэгэхээр Монгол Улсын эрчим хүчний шинэ эх үүсвэрүүд бол төвийн бүсэд Баян, Бөөрөлжүүт, Багануурын станцын өргөтгөл гээд ингэж хийгдэж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энд үйлдвэрлэсэн эрчим хүчийг Хангайн бүс, баруун бүс рүү түгээхэд бол энэ 220-ийн шугам маш өндөр ач холбогдолтой, чухал хэрэгцээтэй учраас энийг дэмжиж байгаа. Тэгээд энэ бол бас нэлээн олон жил яригдсан юм байна лээ. Тэгээд одоо соёрхон батлаад, энэ жилдээ гүйцэтгэгч юм нь шалгараад, бүтээн байгуулалтын ажил нь эхэлчихвэл сайн байгаа. Тийм учраас энэ бол хангайн бүс, Монгол Улсын төвийн бүс, энэ бүс нутгийн эрчим хүчний найдвартай байдалд бол маш чухал ийм төсөл учраас энийг бол дэмжиж байгаа. Гишүүд маань ч гэсэн бас дэмжиж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүнд баярлалаа. Байнгын хорооны хэлэлцэх асуудлын дарааллыг бас дэмжиж байгаа юм байна гэж ойлголоо.

Тэгээд чуулганыхаа төслийг их сайн хийж байгаа юм байна Хосоо гишүүн маань.

Хэлэлцэх асуудал дээр бол саналтай гишүүн алга байна. Хэлэлцэх асуудлаа баталъя. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дүгээр асуудал.

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн 3 дугаар үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Ингээд хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна. Сайдыг микрофонд урьж байна.

3.Мэндсайхан: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банкны хоорондын 17 сая еврогийн “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, төвийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн 3 дугаар үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хамтарсан хуралдаанаар тус тус хэлэлцэн дэмжиж, Ерөнхий сайдын захирамжаар гарын үсэг зурах эрх олгосны дагуу зээлийн болон төслийн хэлэлцээрт 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан.

Энэхүү төслийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд шинээр дэд станц, хос цахилгаан дамжуулах кабель шугам барьж, одоо байгаа Туул дэд станцыг өргөтгөх ажлыг гүйцэтгэх бөгөөд ингэснээр хотын төвийн Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул болон Баянзүрх зэрэг 5 дүүргийн 14 хорооны 1 дүгээр зэргийн хэрэглэгчид болох Улсын 1 дүгээр төв эмнэлэг, 2 дугаар төв эмнэлэг, Өргөө амаржих газар, нийт 11 мянган хэрэглэгчийн цахилгаан, эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа дээшилж, иргэн болон аж ахуйн нэгжүүдийг эрчим хүчээр тогтвортой хангах ач холбогдолтой юм.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу тус хэлэлцээр Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах олон улсын гэрээ тул “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн 3 дахь үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийг танилцуулъя. Сангийн яамнаас Солонгын Тулга Санхүүгийн бодлогын газрын дарга, Лувсандоржийн Гантогтох Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Дашдэлгэрийн Ариунтуул Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Эрчим хүчний яамнаас Бадрыхын Найдалаа сайд. Сайдыг дуудаарай. Эрчим хүчний яамны

Төрийн нарийн бичгийн дарга Ерэн-Өлзий, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ Төрийн өмчит компанийн ерөнхий инженер Даваасамбуугийн Чинбат гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулттай гишүүд байна уу. Хосбаяр гишүүнээр, Анар гишүүнээр тасалъя. Жангабыл гишүүн.

Х.Жангабыл: Баярлалаа. Энэ төвийн бүсийн цахилгаан хангамж түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл дээр 17 сая еврогийн зээлийг авахаар гэрээ хийсэн байна. Бид Их Хурлаар оруулж соёрхон батална. Өнөөдрийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2 дахь хэлэлцэх асуудал “Эрчим хүч 4” гээд 78 сая долларын зээлийг бас авч Их Хурлаар соёрхон батлахаар болж байна. Энэ төслүүдийг дэмжиж байгаа. Дэмжих ч ёстой. Тэгэхээр надад 1 асуулт байна.

Энэ төслүүд бол цахилгаан үйлдвэрлэдэггүй. Гэхдээ шугамын алдагдал саяын дэд станцын үр ашгийг дээшлүүлэх асуудлууд байгаа. Бид цахилгаанаа бас өөрийн өртгөөс хямд зарж байгаа. Тэгэхээр энэ төслүүдийн үр ашиг нь ер нь яаж гарах юм бэ. Энэ зээлийг буцааж яаж төлөх юм бэ. Энэ зээлийг ЦДҮС компани ТӨХК авч байгаа гэж ойлгоод байгаа юм. Энэ компани буцааж төлөх тийм боломж бололцоо байна уу. Эх үүсвэр нь аль эсвэл төсвөөс төлөгдөх юм уу. Энэ дээр хариулт авмаар байна.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгээс 6 номер. Индрийн микрофон дээр.

Б.Ерэн-Өлзий: Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга. Ерэн-Өлзий. Жангабыл гишүүний асуултад хариулъя.

Цахилгаан энэ үр ашгийг дээшлүүлэх өнөөдөр яригдаж байгаа энэ 2 төсөл хоёулаа ЦДҮС компанийн зээл болоод явна. ЦДҮС компанийн зардалд Эрчим хүчний зохицуулах хорооноос эдгээр зээлийн эргэн төлөлтийг хангах зардлыг зохицуулах хороо батлаад явна. Тэгэхээр өмнө нь бол дамжуулах сүлжээн дээр ч гэсэн энэ Чойр, Сайншанд, өнөөдөр ярьж байгаа Мандалговь, Арвайхээр, Сонгинын батарей эд нар гээд яг л энэ дамжуулах сүлжээний үйл ажиллагааны хүрээнд хамаарч байгаа томоохон зээлийн төслүүд ингээд Засгийн газрын урт хугацааны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр гэсэн нэрийн доор дамжуулангийн гэрээ байгуулагдаад ингээд явж байгаа. Энэ бол дамжуулах компанийнх нь зардалд нь энэ зээлийн эргэн төлөлтийг нь Эрчим хүчний зохицуулах хороо тухай бүр тусгаад ингээд явж байгаа.

Г.Тэмүүлэн: Болсон уу. Нэмж хариулах уу. Жангабыл гишүүн нэмж тодруулъя.

Х.Жангабыл: Үгүй ээ. Эрчим хүчний зохицуулах хороо төлнө гэж байхгүй л дээ. Эрчим хүчний зохицуулах хороо үнэ тогтоох байгууллага. Тэгэхээр энэ эх үүсвэрийг нь яаж төлөх вэ гэдэг дээр бүрэн хариулт авмаар байна.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Найдалаа сайд.

Б.Найдалаа: Жангабыл гишүүний асууж байгаа энэ асуулт маш чухал асуулт. Яагаад гэвэл энэ авч байгаа зээлүүд ТӨК дээр авч байгаа. Өмнө нь авч байсан. Цаашдаа ч гэсэндээ авах шаардлагатай, ер нь авах ёстой санхүүжилтүүд байгаа юм. Гэхдээ гагцхүү асуудал нь юундаа байна вэ гэхээр үнэ тарифын асуудлаас

болоод энэ компаниуд хиймлээр гэдэг юм уу алдагдалтай ажиллачхаад байгаа юм. Алдагдалтай ажиллаад ирэхээр зээлжих чадвар нь муудаад, дахиж зээл авах боломжгүй болоод, тэгээд бүтээн байгуулах ёстой дэд бүтцийн ажлуудаа, эх үүсвэрүүдээ барьж чадахгүй болчихоод байгаа юм. Уг нь бол энэ ДЦС-ууд, энэ ЦДҮС, цахилгаан түгээгч адилхан. Яг зээлжих чадварын хувьд бол хөрөнгөтэй мөнгөтэй, гол нь мөнгөн урсгал орлогын хувьд асуудалтай болчихоод байгаа болохоор өмнөх зээлүүдээ төлж чадахгүй болчихоод, үүнээс болоод эргээд яг таны хэлж байгаа эргэн төлөлт нь муу болоод ирэхээр нэмж барих ёстой тэр шугам, дэд бүтцийг барих боломжгүй болчих гээд байгаа ийм гажуудал үүсээд байгаа юм. Тэгэхээр цаашдаа түрүүн хариулж байгаа тэр эрчим хүчний зохицуулах хороо гэж байгаа юм. Зохицуулах хороо дээр орлогыг нь хуваарилж байгаа болохоор үнэ, тариф, орлогын хуваарилалтыг зээлийн эргэн төлөлтөө хийхүйц болж өгөөд тэгээд энэ компаниудаа санхүүгийнх нь хувьд зээлжих чадварын хувьд сайжруулж чадах юм бол бид нар жишээлбэл ДЦС 4 бол өөрөө зээлээ аваад, өөрөө зээлээ эргэн төлөх тэгээд бүтээн байгуулалтаа хийгээд эх үүсвэрээ нэмээд явах, засвар үйлчилгээ хийх боломжтой юм байгаа юм. Тэгээд энэ талаас нь санхүүгийн загварын өөрчлөлт хийх шаардлага үнэхээр яах аргагүй байгаа.

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр гишүүн асуулт асууя.

Ж.Энхбаяр: Энэ гадаад зээлийн гол ашиглалтыг эрчим хүчний салбар луу чиглүүлж байна. Тэгээд өвөлжилтийн бэлтгэл ажил ер нь эрчим хүчний нөхцөл байдал ямар байна. Дамжуулах, түгээх сүлжээнүүдийн байдал ямар байна. Цаашдаа гол анхаарах юмнууд юу байна. Ахиж шаардлагатай эх үүсвэрүүд юу байна. ТЭЦ 3, 4-ийн нөгөө турбинуудын засварын ажил юу болж байна гээд товчхон мэдээлэл өгөөч. Ялангуяа энэ Байнгын хороо дээр анхаарах, анхаарлын төвд байлгаж дэмжих асуудлууд юу байна гэж.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Найдалаа сайд хариулах уу. Найдалаа сайд.

Б.Найдалаа: Төрийн нарийн бичгийн дарга хариулчих. Би нэмж хариулъя.

Г.Тэмүүлэн: Индрийн микрофон.

Б.Ерэн-Өлзий: Төрийн өмчит компаниудын бизнес төлөвлөгөө оны эхнээс батлагдахтай зэрэгцээд, тухайн компаниуд дээрх тухайн дулааны улирал, бага ачааллын үеийг ашиглаж бүх засвар шинэчлэлийн ажлуудын төсөв, график батлагдаад ингээд явдаг. Зуны бага ачааллын үеийг ашиглаад манай ДЦС-ууд, тухайн зуух турбины хэсэгчилсэн зогсолтоо хийгээд, засвар шинэчлэлийн ажлаа бол хийж явж байгаа. Энэ оны тухайд бол нийт 27 төрийн өмчит компани дээр 230 орчим тэрбум төгрөгийн засвар шинэчлэлийн ажлууд батлагдсан. Өвөлжилтийн бэлтгэл ажил бол яг хуваарийнхаа дагуу өнгөрсөн оны мөн үетэй харьцуулах тэр тоон дээрээ бол явж байгаа. Үүнээс гадна Засгийн газраас бас зардал хүрэлцэхгүй байгаатай холбогдуулаад ДЦС-уудын засвар шинэчлэл дээр бас зуухны засвар шинэчлэлтээр нэмж 5 тэрбум төгрөгийн асуудлыг Засгийн газрын нөөц сангийн эх үүсвэрээр шийдвэрлэж өгсөн. Энэ эх үүсвэрээр хийгдэх ажлууд бас гүйцэтгэгчээ тодруулаад ажлууд эхэлсэн байгаа.

Ер нь бол нийт 27 компаниас засвар шинэчлэлийн ажлын санал нь компаниас гарч ирэхдээ нийлбэр бол 560 орчим тэрбум төгрөгийн хүсэлт гарч ирж байгаа юм. Яг орлогын боломжтойгоо уялдуулаад 230 орчим тэрбум төгрөгийн бодит засвар шинэчлэлийн зардлыг тухайн компанийнх нь ТУЗ-үүд зохицуулах хороотой

зөвшилцөж байгаад баталж өгсөн гэсэн үг. Тэгэхээр бүрэн засвараа бол төлөвлөсөн бүрэн засвараа одоо юу гэдэг юм цаг хугацааны хувьд, стандартын хувьд шахагдаж байгаа бүрэн засваруудаа бол 100 хувь хийж чадаж байгаа гэхэд бол хүндрэлтэй. Тэгэхээр 50 хувьтай л хийж байгаа гэсэн үг. Бодит орлоготой баригдаад.

Г.Тэмүүлэн: Найдалаа сайд нэмж, тодруулж хариулъя.

Б.Найдалаа: Энхбаяр Шадар сайдын асууж байгаа асуулт, тавьж байгаа асуудал үнэхээр яг энэ салбарын гол зангилаа асуудал яг энд байгаа юм. Олон жилийн турш хийх ёстой засвар үйлчилгээг төсөв мөнгөний гэдэг асуудлаас шалтгаалаад, бас нэг талаасаа шалтаглаад дандаа дутуу хийж ирсэн. Энэ жил ч гэсэн яг дутуу хийж байгаа. Тэгэхээр яах аргагүй доголдол гарах эрсдэл бол хаагдаж чадахгүй. Яг бодитой байдал нь ердөөсөө яг тийм байгаа юм. Тэгэхээр энэ дээр явж явж асуудал нь юундаа байна вэ гэхээр яг түрүүний ярьж байгаа тэр үнэ, тарифын асуудал. Зөвхөн үнэ тарифын асуудал биш хажуугаар нь бас яг зардлын эрэмбийн асуудал, үр ашгийн асуудал, цалин мөнгөний асуудал бас ороод явна. Аль нь хэзээ, яаж нэмэх ёстой юм. Засвар үйлчилгээ яаж сайжруулах ёстой юм гээд ер нь зүгээр санхүүгийн санхүү хөрөнгө оруулалтын эрчим хүчний салбарын тогтолцоо, тэр өр зээлийн асуудал, үнэ тарифын асуудал засаглалын.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж, гүйцээж хариулъя.

Б.Найдалаа: Тэгээд бид нар энэ эрчим хүчний салбар дээр шинэчлэлийн ажил гээд байгаа нь эд нарыг иж бүрнээр нь бүгдийг нь тооцож хийхгүй бол зөвхөн үнэ тарифыг нэмээд болчих юм байна гэвэл бас болоогүй гэдгийг угаасаа амьдрал харуулсан. Зөвхөн цалинг нэмээд бас биш байгаад байгаа юм. Зөвхөн засвар үйлчилгээ гээд мөнгө нэмж өгөөд байх юм бол энэ чинь бас үр ашгийн асуудал гарна. Ингээд бүгдийг нь цогц байдлаар шийдэхгүй бол болохгүй болчхоод байгаа юм. Тэгэхээр яг энэ дээр бол нийлүүлж байгаад бас намраас яг тэр Засгийн газрын түвшинд санхүү, хөрөнгө оруулалтынх нь асуудалтай нийлж байгаад багцаар нь шийдэх ёстой гэж бодож байгаа.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн тодруулъя.

Ж.Энхбаяр: Тэгэхээр хойд хөрш маань дайны байдалтай байгаа. Ялангуяа газрын тос боловсруулах гол гол үйлдвэрүүдийнхээ дийлэнх хувийг засварын байдалд шилжүүлсэн. Цохилтод өртсөн. Нөгөө талдаа эрчим хүчний хангамж бас энийгээ дагаад доголдох асуудлууд бодит байдал үүсэж байгаа юм. Тэгэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор намар тийшээ ер нь энэ эрчим хүчний асуудлыг эдийн засгийн агуулгаас нь илүү аюулгүй байдлын агуулгаар үзээд, цогцоор нь бодлого зөвлөмж гаргаад, Засгийн газарт чиглэл өгөөд, Их Хурлын дагалдах тогтоолыг шийдээд, анхаарахгүй бол нөгөө талаасаа өвлийн ОХУ-аас авдаг 200мвт, 300 хүртэл авдаг мегаваттыг ер нь авахгүй гэж бодож тооцоод, ачааллаар тооцоорой. Ер нь илүүлэх юмгүй л болж хувираад байна шүү. Яагаад гэвэл газрын хийн дээр тулгуурлаж байсан станцууд нь нэлээн эрсдэлд ороод эхэлчихсэн. Үйлдвэр системүүд нь доголдоод эхэлчихсэн. Ноднин бол нэлээн юм болж байж бид нар авсан. Одоо бол дутна гэж бодоорой. Тэгэхээр дутна гэж бодсон тооцоон дээр хийж ер нь эрсдэлээ тооцохгүй бол бүх юм болсны дараа бид мянга хуралдаад нэмэргүй шүү дээ. Тэрийг анхаарч ажиллана биз дээ.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүнд баярлалаа. Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Түрүүн хэлсэн энэ төсөл, энэ зээлийн хэлэлцээрийг соёрхон батлахыг бол дэмжиж байгаа. Манай хангайн бүс нутаг буюу Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймаг бол эрчим хүчний Эрдэнэт, Булганы цахилгаан түгээхээр дамжуулаад 110-ын шугамаар 1 эх үүсвэрээс цахилгаанаа авдаг. Тэгээд эрчим хүчний бол маш найдваргүй байдалд байгаа. Одоо тэр 3 аймагт, энэ хангайн бүс нутагт бол шинэ үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, шинэ бизнес эрхлэх, шинэ барилга байшин барихад бол техникийн нөхцөл олгогдохоо байчихсан. Тэр дундаа 380-ын техникийн нөхцөл бол бүр олгохоо байчихсан. Зогсоочихсон байх жишээний. Тэгэхээр энэ зээлийн хэлэлцээрийн хүрээнд бол Мандалговь, Арвайхээр чиглэлийн 220 киловаттын агаарын цахилгаан дамжуулах хос шугам баригдах юм байна лээ. Тэгэхээр энэ шугам баригдсанаар бол төвийн бүсэд буюу Баян, Бөөрөлжүүт, Багануурын цахилгаан станцын өргөтгөл зэрэг энд үйлдвэрлэж байгаа цахилгаан эрчим хүчийг төв төвийн бүс рүү авахад бол маш чухал. Тэгээд энэ төвийн бүс, хангайн бүсийн эрчим хүчний найдвартай байдал нэмэгдэнэ. Мөн чадлын дутагдалд орохгүй ч гэдэг юм уу ингээд маш чухал ач холбогдолтой ийм төсөл, ийм ажил, энэ төслийг санхүүжүүлэх хэлэлцээр учраас ингээд дэмжиж байгаа. Тийм учраас энэ ажлыг хурдан эхлүүлэх шаардлага байгаа.

Тэгээд Сангийн яамнаас 1 асуух асуулт байгаа. Гадаад зээллэгийн нөгөө ашиглалт, нөгөө тааз тулчихсан гээд ирэх жилүүдэд бас жоохон юм дусаагаад явчихгүй биз дээ. Нэгмөсөн баталж байгаа хэлэлцээр мөнгөн дүнтэй ажлуудаа тулгаад тулгаад явбал яадаг юм бэ. Энэ дээр ер нь ямар хариулт хэлэх вэ гэж асууя.

2 дугаарт нь Эрчим хүчний сайдаас нөгөө 10 аймгийн дулааны станц дээр мэдээлэл өгөх боломж байна уу. Нөгөө 10-аад жил гацаж байгаа дулааны станц маань бас сураг сонсогдоод байгаа. Тэгэхдээ ямар ч байсан Солонгосын талыг хүлээгээд бол бүтэхгүй байх. Тийм учраас бид нар ер нь өөр ямар нэгэн арга замаар ямар боломж, бололцоо байна. Би бол 2, 3 жилийн өмнөөс л хэлээд байгаа. Хувийн хэвшлийнхэн бол уг нь санал тавиад л яваад байдаг юм байна лээ. Үлдэгдэл санхүүжилтийг нь хийгээд, дуусгаад тодорхой хувийг нь эзэмшээд, ашиглаад явъя. Одоо жишээ нь Өвөрхангай аймаг дээр баригдаж байгаа станц чинь гэхэд 45 хувийн гүйцэтгэлтэй байгаа шүү дээ. Тэгтэл энэ дээр бас удаашралтай байгаа. Энэ дээр Найдалаа сайд мэдээлэл хэлээч.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Найдалаа сайд.

Б.Найдалаа: 10 аймгийн дулааны станцын асуудал гацсан байгаа. Тэгээд ер нь 47 хувийн гүйцэтгэлтэй. Солонгос талын гүйцэтгэгч компанийн ер нь буруугаас үндсэндээ болоод зогссон байгаа. Өнгөрсөн 7 хоногт Засгийн газрын хурлаар яг энэ асуудлыг оруулаад, тэгээд шийдлийг нь санал болгоод, одоо албажаад гарч байгаа байх. Мэндсайхан сайд бас тодруулаад хэлэх байх. Энэ үлдэгдэл санхүүжилтийг нь улсын төсөвт тусгаад, ер нь цаг алдахгүй хэрэгжүүлье гэсэн шийдэл дээр тогтсон байгаа. Тэгээд бусад түүнтэй холбоотой хэлцлүүдийг Сангийн яамнаас, Засгийн газраас хариуцаад хийгээд шийдээд явах байх.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс хариулъя. Индрийн микрофон.

С.Тулга: Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга. Гишүүний асуултад хариулъя. Өрийн хязгаар 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар ДНБ-д эзлэх хувиар гаргах юм бол 37,5 хувьтай байгаа. Төсвийн хүрээний мэдэгдлээр манай энэ хязгаар бол 50 хувь. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу бол 60 хувь байгаа. Тэгээд сая бол Гадаад зээлийн эрчимжүүлэх хууль

батлагдсанаар одоо яг нөгөө гацаад байгаа асуудал нь бол төсөв дээр тусгах, алдагдлын хэмжээнд тулгах ийм асуудлууд байгаа. Яг өрийн хязгаар талдаа бол орон зай бол байгаа. Тэгээд сая 2 төслийг энэ хуулиар эрчимжүүлснээр тодорхой хэмжээний орон зай төсөв дээр үүсээд ингээд явна гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Мэндсайхан сайд нэмж мэдээлэл өгье.

3.Мэндсайхан: Тэр өрийн хязгаарт бид нар өрийн хязгаарлалтаас зээлийн ашиглалтын хязгаарлалтаас 2 том төслөө гаргачихсан учраас нөгөө үлдэж байгаа 74 төсөл дээрээ бид нарт бас тодорхой орон зай гараад явж байгаа. Тэгэхээр энэ дээр бол зээл ашиглалт дээр хүндрэл гарахгүй байх. 10 аймгийн асуудал дээр сая Засгийн газар дээр эрчим хүчний яам саналаа оруулж ирсэн. Тэгээд бид нар Засгийн газрын хурал дээр хэлэлцэж байгаад төсвөөрөө явъя. Тэгэхгүй бол төсвийн хөрөнгө оруулалтаар явахгүй бол энэ өнгөрсөн хугацааг нь харах юм бол энэ чинь бараг 10-аад жил үргэлжилсэн. Дахиад цааш нь үргэлжлүүлээд явна гэх юм бол яах вэ бид нарт Солонгосын талын тэр шүүхийн маргаан, өмнөх гүйцэтгэлийн асуудал гээд дахиад хугацаа хэр үргэлжлэх дээр бол тодорхойгүй. Тэгэхээр энэ эхэлсэн ажлуудыг яаралтай дуусгая гэдэг дээр Засгийн газар ерөнхийдөө тогтсон.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Өглөөний мэнд. Сангийн яам, Эрчим хүчний яам 2-оос асууя. Энэ олон улсын зээл, хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа эрчим хүчний магистрал шугамын төсөл хөтөлбөрүүд хэрэгжихдээ маш их уддаг. Сонгон шалгаруулалтаа хийхдээ уддаг. Төсөвт өртөг нь 20-30 хувь үнэтэй байдаг. Энэ дээр дандаа гаднын компаниуд орж ирдэг. Үндэсний 1 ч компани орох техникийн шалгуур үзүүлэлтүүд нь хангадаггүй ийм байдалтай удаан явж ирсэн. Энийг байнга л ярьж байгаа. Тэгэхээрээ Сангийн яам цаашдаа энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар энэ аймаг, хот хоорондын хооронд магистрал шугамаа хийх төлөвлөгөө бий юу. Өртөг багатайгаар.

Эрчим хүчний яам энэ олон улсын төсөл, хөтөлбөрүүдтэй хэлэлцээр хийхдээ техник, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт дээрээ үндэсний компаниудаа оролцуулах хэлэлцээрийн хэлцлийг хийж чадаж байна уу. Одоо Бөөрөлжүүт, Багануурын эрчим хүчний 220-ийн шугам үндэсний 7 компани хувааж хийсэн. Нийт төсөвт өртөг нь олон улсын хөтөлбөрүүдээс хугацааны хувьд 2-оос 3 дахин бага, өртгийн хувьд 20-30 хувь дахин бага. Одоо дахиад Бөөрөлжүүт, Сайншанд явж байна. 2 жилийн дотор хийгдэж байгаа. Тэгээд бусад энэ магистрал шугамууд маань болохоороо бид нар дандаа төсөвт өртөг өндөртэй, 4-5, зарим нь 5-7 жил болсон хугацаа зарж, тэгээд үндэсний компаниуддаа ээлгүй ийм томоохон эрчим хүчний шугамуудыг тавиад байгаа асуудал дээр Эрчим хүчний яам хэрхэн ямар бодлого барьж байгаа вэ.

Мөн энэ дээрээ Сангийн яам нь цаашдаа ер нь үндэсний аюулгүй байдлын хамгийн чухал асуудал чинь Ж.Энхбаяр сайд ч ярьж байна. Эрчим хүч болчихоод байгаа. Тэгэхээр улсын төсөв дээрээ тавьж, өртөг багатайгаар хурдан шуурхай хийх дээр ямар бодлого баримтлах вэ.

Г.Тэмүүлэн: Анар гишүүний асуултад хариулъя. Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Энэ ерөнхийдөө дэд бүтцийн ажлуудаа бид нар гаднын хөнгөлөлттэй зээлээр хийгээд явж байгаа. Энэ бол ерөнхийдөө л бид нарын төсвийн орлоготой шууд хамааралтай. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийхэд болохгүй гэх

зүйлгүй. Гэхдээ бид нарын өнөөдрийн орлого болон урсгал зардлын харьцаа, мөн нийгмийн шинж чанартай хөрөнгө оруулалтын асуудлууд байгаа. Сургууль, цэцэрлэг, орон нутагт тулгамдаж байгаа улс орон даяар эндээ бид нар орлогын хэмжээнд тохируулаад, үлдсэн дэд бүтцийн том бүтээн байгуулалтын асуудлаа урт хугацааны хэрэг. Гэхдээ Сангийн яамны барьж байгаа бодлого бол нийгэм, эдийн засгийн өгөөжөө өгөх том төслүүд рүүгээ гаднын зээлээ ашиглая гэсэн энэ бодлого дээр явж байгаа.

Сонгон шалгаруулалтын хувьд ерөнхий зээлийн хэлэлцээр дээр бид нар тавьж байгаа үндсэн шаардлага бол тухайн зээлийн ашиглалтын явцад монголын талын дотоодын туслан гүйцэтгэгчийг тухайн гүйцэтгэлийн тоног төхөөрөмж, техникийн шинж чанартай зайлшгүй импортоор авахаас бусад зүйл дээр нь дотоодын аж ахуйн нэгжийг оруулах ёстой гэдэг зээлийн хэлэлцээрийн ерөнхий чигийг барьж байгаа. Сонгон шалгаруулалтын асуудал бол мэдээж салбар яам нь зохион байгуулаад явах асуудал байгаа. Тэгээд Найдалаа сайд тэр дээр нь нэмээд хариулчих.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс хариулъя. Индрийн микрофон.

Б.Ерөн-Өлзий: Эрчим хүчний салбарт 220 киловольтын түвшний дамжуулах шугамын төслүүд хамгийн эхний Монгол Улсын хувийн хэвشلүүд үүсэж хөгжөөд хийсэн ажлууд нь болохоор Мандалговь, Тавантолгой, Оюутолгойн шугам байгаа юм. Тэрний дараа Сонгино, Мандалговь гээд үргэлжлээд явсан. Сүүлийн жилүүдэд хувийн цахилгаан станцын хөрөнгө оруулалт болон тухайн хувийн станцын дамжуулах сүлжээтэй холбоотой ажлууд бас гарч ирж, манай үндэсний компаниуд энэ ажлуудыг голцуу гүйцэтгэж байгаа. Үндэсний аж ахуйн нэгжүүд бол яг 220 киловольтын шугам, дэд станцын ажлыг бол хийгээд одоо бол ер нь сурчихсан. Тоног төхөөрөмжтэй болчихсон байгаа. Олон улсын энэ хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төслүүд дээр гарч байгаа гол хүндрэлүүд нь болохоор Багануур, Чойр, Мандалговь, Арвайхээр гээд энэ төслүүд дээр ярьж байгаа нь нийт санхүүжилтийн өртөг нь бол өндөр, банкнууд аль болохоор .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Гүйцээгээд хариулъя.

Б.Ерэн-Өлзий: Борлуулалтын орлого, санхүүгийн баталгаатай ийм компаниудаар төслийн гүйцэтгэлийг хийх гэдэг заавал олон улсын тендер зарлуулах шаардлага тавьдаг. Бидний зүгээс дотоодын компаниуд энд оролцох боломжийг хангахын тулд аль болохоор төслийн дотор нь багц болгож хуваах ийм бодлого барьж байгаа. Тухайлбал, одоо зарлачихсан явж байгаа Дэлхийн банкны Багануур, Чойрын шугамыг бид нар 3 багц болгож хуваасан байгаа. 3 багц болгож байгаа нь аль болохоор дотоодын компаниуд хоорондоо нэгдээд орох эсвэл гаднын компанитай түнш хэлбэрээр орох ийм боломжийг нь нээхийн тулд багцууд болгож хувааж, Мандалговь, Арвайхээрийг бас ингэж багцууд болгож хувааж зарлана гээд банктai ярилцаад явж байгаа. Ингэснээрээ бас манай дотоодын компаниуд түншлэлийн гишүүн болж орж ирэх ийм боломж нь бүрдэж байгаа. Төслийг 1 багц болгоод зарлачихаар дотоодын компаниуд шууд гэрээ байгуулагч болж орж ирэх боломж нь хаагдаад байгаа. Тэгэхээр бид нар энэ шугамууд дээр аль болохоор багц болгож хуваах асуудлыг банкнуудтай ярилцаж явж байгаа.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулъя. Анар гишүүн.

Ч.Анар: Энэ багц болгож задалж байгаа нь бол их сайн хэрэг байна. Ер нь энэ хөнгөлөлттэй зээл гэдэг нэр дээр нийт төсөвт өртгүүд нь дандаа өндөр өртөгтэй орж

ирдэг асуудлыг цаашдаа багасгахгүй бол болохгүй байна. Хөнгөлөлттэй боловч анхны төслийн өртөг нь өндөр болохоор энэ хөнгөлөлттэй зээлийн утга агуулгууд Монгол Улсын хэрэгжүүлж байгаа бүх төслүүд дээр харагдахгүй байгаад байгаа юм.

Найдалаа сайдаас 1 зүйл асууя. Их Хурлын даргын 119 дүгээр тогтоол. Эрчим хүчинд чиглэл өгөх, Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоол батлагдсан. Эдийн засгийн байнгын хороо дээр өчигдөр давхардсан чиг үүрэгтэй тогтоол орж ирснийг хойшлуулсан. Энэ дээр Их Хурлын дарга өчигдөр чуулганы нээлт дээр Улаанбаатар хот хөлдөх юм бол Анар гишүүн хариуцна шүү гэж хариулж байна лээ. Тэгэхээрээ та хариуцах юм уу, би хариуцсан юм уу. Улаанбаатар хот хөлдөх гэж байгаа юм уу та энийг хариулж өгөөч. Энэ тогтоол яаралтай хэрэгжихгүй бол Улаанбаатар хот хөлдөөд, би хэрэгт орохоор байгаа юу Найдалаа сайдаа.

Г.Тэмүүлэн: Найдалаа сайд Анар гишүүний асуултад хариулъя.

Б.Найдалаа: Улаанбаатар хот хөлдөх эсэх нь мэдээж хэрэг чиг үүрэгээрээ Эрчим хүчний сайдаас шууд хамаарна. Гэхдээ энэ бол одоо яг тогтоол гарснаараа шууд хөлдөхөө больчихно. Эсвэл хөлдөхөөр болчихно гэсэн юм бол байхгүй. Олон жилийн хийх ёстой ажлыг хийж ирээгүйгээс болоод, зарим бодлогын алдаанаас болоод эрчим хүчний салбар Монгол Улсын гал ийм хүнд байдалд орсон нь яах аргагүй үнэн. Тэгэхээр би давтан хэлж байгаа. Ер нь бол түрүүн Энхбаяр Шадар сайд ч хэлж байна. Шинээр үүсэж байгаа нөхцөл байдалтай холбоотой бид нарын эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл эрсдэлтэй хэвээр байгаа. Эрсдэл нь харин ч нэмэгдэхээр байгаа. Тэгэхээр эрсдэл байгаа гэдгийг хэлж байгаа шүү. Эрсдэлийг үгүй байлгахын төлөө бүхий л талаар бодлогын болон хэрэгжилтийн арга хэмжээг авч ажиллаж байгаа. Зүгээр Их Хурал дээр тогтоол гараад, тэр нь зарим нь ялангуяа тэр санхүү, хөрөнгө оруулалтын шийдэлтэй холбоотой, Их Хурлын чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомжтой холбоотой Засгийн газарт .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Гүйцээж хариулъя.

Б.Найдалаа: Засгийн газарт чиг өгөхүйцээр тийм тогтоол агуулга бол бас хэрэгтэй. Яг зүгээр Засгийн газар дээр угаасаа шийдэх боломжтой зарим зүйл угаасаа тогтоол гарчихсан, ярилцчихсан, хэлэлцчихсэн, салбарын яаман дээр хийгээд явж байгаа ажлыг бол энд өмнөх тогтоолоо ч давтан гаргах шаардлагагүй. Гэхдээ холбоотой бас 2, 3 заалт байх нь байсан. Тэгэхээр тодорхой байгаа байх. Мэдээж хэрэг эрсдэлийг, хариуцлагыг бол Засгийн газар болон Эрчим хүчний яам хариуцаад явж байгаа. Гэхдээ бас яг зөв шийдлийг нь гаргаж өгөх, бас магадгүй зарим тохиолдолд шаардлагагүй зүйлээр манай гишүүд маань Их Хурлын орчинд улс төрийн асуудал болгочихгүй байх тэр талаас нь анхаараад дэмжээд өгөхөд болно гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Би ганц 2 саналууд бас хэлээдэхье.

Нэгд, зүгээр зохион байгуулалттай холбоотой Засгийн газар бас дараа дараадаа анхаарах асуудлууд байна. Энэ 7 сарын 2 гээд 3 асуудал, зээлийн хэлэлцээрүүд соёрхон батлах хуулийн төслүүд орж ирж байгаа. Тэгээд энэ дээр дараа дараадаа Засгийн газар бас зохион байгуулалтаа илүү сайжруулаад, чуулганы төгсгөл рүү хамгийн сүүлийн өдөр лүү оруулж ирэх бас их зохистой биш. Тэгэхээр энэ дээр бас анхаараарай. Ер нь Их Хурал ч гэсэн бид нар сүүлийн 7 хоногт нь ингэж шуурхайлж, шахаж хууль өргөн барихыг ер нь бас хориглох нь зүйтэй юм

болов уу л гэсэн ийм хувийн саналтай байна. Гишүүд ч гэсэн энэ асуудал дээр бас бухимдалтай байна. Дахиад энэ 3 асуудлын дараа, дахиад 3 асуудал бас орж ирсэн байна. Өчигдөр өргөн барьсан. Тэгэхээр магадгүй яг хоног хугацаагаараа, дэгээрээ гээд явах юм бол дараа 7 хоногийн, 1 дэх, 2 дахид бас дахиад хуралдах ийм асуудлууд байна. Чуулган завсарлалчигсаны дараа ирц бүрдэхгүй байх ч эрсдэлтэй асуудлууд байна шүү. Тэгэхээр мэдээж юу гэдэг юм КОП болох гэж байгаа асуудал. Энэ чинь олон жилийн өмнөөс тодорхой болчихсон. Гаднын Ерөнхийлөг, төрийн тэргүүнүүд ажиллах гэж байгаа асуудлууд эд нар чинь бас хэдэн сарын өмнө тодорхой болчихсон асуудлууд. Тэгэхээр хоног хугацаагаа шахаж байж, цаг хугацаатай төлөвлөж байж хийж байхгүй бол бас ийм алдаатай зүйл байна.

2 дугаарт Сангийн яамны Өрийн удирдлагын газрынхан орж ирсэн байна. Сангийн сайд Мэндсайхан сайд өөрөө байна. ОУВС-ийн 6 сарын 26-нд гаргасан дүгнэлтээ сайн үзээрэй. Бодлогын алдаагаа засаж залруулаарай. Энэ дээр чинь цагаан дээр хараар та бүхний хийсэн алдаануудыг бүгдийг нь тодорхой биччихсэн байгаа. Бид нар ч энэ асуудлуудыг сая сүүлийн хугацаанд хэлж ярьж байсан. 2024 оны 08 сард та бүхэн суурь зарлага, суурь тэнцэл гэдэг олон улсад байхгүй стандарт бус зүйлийг гаргаж ирээд, зардлаа нэмэх, өсгөх, хэмжээгээ нэмэгдүүлэх, төсвийнхөө сахилга батыг алдагдуулах алдаа хийсэн.

Сая сүүлд 2026 оны 06 сард энэ 2 мега төслөө төсвөөсөө бас гаргаж хаяж, энэ 2 төслөө эрчимжүүлэх гэдэг нэрийн дор ингээд бас төсвөөсөө гаргасан. Энэ бол мэдээж зүгээр төсвийнхөө зарлага, зардал хэмжээгээ л нэмэгдүүлж байгаа л стандарт бус шийдвэр. Энэ бол үндсэндээ бодлогын алдаа. Тэгэхээр би хэлэх гээд байгаа зүйл нь бол одоо бид нар бас засаж залруулах бодлогын хандлагаа зөв болгох асуудал дээр бас анхаарах ёстой шүү. Та бүхэн тэгээд магадгүй зөв болгох хуулийн төслөө гэдэг юм уу, хоног хугацаагаа бас тооцож орж ирж байгаад өргөн бариад ингээд шийдээд явах нь зөв байх. Магадгүй 2 жилийн дараа, 3 жилийн дараа ч гэдэг юм уу энийгээ бид нар төсөв, сахилга бат, дүрмээ мөрдөөд явъя гэдэг асуудлуудыг хийх ёстой шүү. Тэгэхгүй бол бид нар өөрсдийгөө хуурч байна гэж бодоод байдаг. Өрөөлийг хуураад байдаг. Гадаад орчиндоо бид нар бас муухай харагдаад байдаг. Олон улсын байгууллагууд ч бид нарыг бас стандарт бус, дүрмийн бус ийм зүйл хийгээд байна шүү дээ гэдгийг бол хэлээд байгаа. Би бүр онцлоод хэлэхэд саяын тэр яг ОУВС-ийн 06 сарын 26-ны дүгнэлт дээр энэ 2 төсөлтэй чинь холбоотой гадаад зээл, тусламжийн төслийг мега төслөө төсвөөсөө гаргаж байгаа асуудлуудыг чинь 2, 3 удаа энд дурдаж хэлсэн байгаад байгаа юм.

1 дүгээрт энэ бол үндсэндээ танай төсвийн чинь сахилга бат, төсвийн чинь менежмент гэдэг зүйл бол үндсэндээ байхгүй боллоо шүү. Гаргаж байгаа чинь үндсэндээ олон улсын стандартад нийцэхгүй байна. Энийгээ анхаараарай гэдэг зүйлийг бичсэн байгаад байгаа юм. Энэнээс чинь үүдэлтэйгээр 2026 оны төсвийн тэнцэл болоод төлбөрийн тэнцэл чинь бас хүндрээд байна шүү. Энэ бол ихэнхдээ яг та бүхний энэ 2 төслийг гаргасантай холбоотойгоор, төсвийн дүрэмтэй холбоотойгоор гэдэг асуудлыг бүр онцолж хэлсэн байгаад байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө нэг талдаа бид нар сайн зүйл хийж байгаа юм шиг тухайн үедээ ухуулж сурталчилж яриад байсан боловч урт хугацаандаа улс орныхоо эдийн засаг, төсөв, санхүүдээ ийм бодлогын алдаа гэх юм уу том төөрөгдлийг бид нар бас хийгээд байгаа. Залруулах бол зайлшгүй шаардлагатай шүү. Анхаарч ажиллаарай. Тэгээд хуулийнхаа төслүүдийг зөв болгоод яахгүй бол бидэнтэй харьцдаг, уулздаг, учирдаг ОУБ ч гэж байхгүй болно шүү яг үндсэндээ бол. Энийг бас анхааруулж хэлж байгаа юм шүү.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтдаа оръё. Санал хураалтаа явуулъя.

Ингээд Зээлийн болон төслийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалтад бэлтгээрэй. Манайхан хариуцлагатай оролцоорой. 9-үүлээ байна.

Зээлийн болон төслийн хэлэлцээрийг соёрхон батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 56,3 хувиар дэмжигдлээ. Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр гишүүн илтгэнэ.

12.10 цаг.

2 дахь асуудалдаа орцгооё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. 2 дахь асуудал.

Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч 4” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд мөн адил. Танилцуулгыг Сангийн сайд Загджавын Мэндсайхан сайд танилцуулна. Микрофонд урьж байна.

3.Мэндсайхан: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын 78 сая ам.долларын “Эрчим хүч 4” төслийн зээлийн хэлэлцээрийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 03 сарын 31-ний өдрийн хуралдаан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны 2026 оны 04 сарын 15-ны өдрийн хамтарсан хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Ерөнхий сайдын захирамжаар гарын үсэг зурах эрх олгосны дагуу зээлийн хэлэлцээрт 2026 оны 05 сарын 08-ны өдөр гарын үсэг зурсан.

“Эрчим хүч 4” төслийн хүрээнд шинээр Мандалговь, Арвайхээр чиглэлийн 287км урттай 220квт-ын цахилгаан шугам, агаарын шугам болон Өвөрхангай дэд станцыг шинээр барих, Баянхонгор, Арвайхээр, Мандалговь дэд станцыг өргөтгөх ажлууд хийгдэх бөгөөд төслийг хэрэгжүүлснээр бүс нутгийн 50 мянга гаруй хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа дээшилж, хангайн болон баруун бүсийн аймгуудад төлөвлөж буй хөгжлийн хөтөлбөрүүдийг эрчим хүчний хангамжаар бүрэн хангах боломж бүрдүүлэх ач холбогдолтой.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу энэхүү зээлийн хэлэлцээр нь Улсын Их Хурлаар заавал соёрхон батлах олон улсын гэрээ тул “Эрчим хүч 4” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Үг хэлэх гишүүд байна уу. Жангабыл гишүүнээр тасалъя. Жангабыл гишүүн.

Х.Жангабыл: Энэ 2 төслийг бол соёрхон батлахыг бүрэн дэмжиж байгаа. Сая Энхбаяр Тэргүүн Шадар сайд маань бас саналаа хэлж байна. Би санал 1-тэй. Ер нь энэ жил бол их эрсдэлтэй гээд Найдалаа сайд ч бас хэлж байна. Бид энэ эрчим

хүчний хараат байдлаас яаралтай гарах хэрэгтэй. Миний хэлэх гэж байгаа юм болбол Оросын Холбооны Улсад газрын тосны бүтээгдэхүүний асар их хомсдолтой байна. Энэ хомсдолоосоо болж бидэнд нийлүүлэх эрчим хүчийг тухайн үед оргил ачааллын үед өвөл ялангуяа хязгаарлах магадлал маш өндөр. Тэр байтугай манай цахилгаан станцуудын нүүрсний хангамжийг сайжруулах хэрэгтэй байна Найдалаа сайд аа. Яагаад гэхээр одоо ингээд наадам боллоо. 08 сарын 01 хүртэл бүх төрийн албан хаагч нар ерөнхийдөө амардаг шүү дээ. 08 сарын 01-ээс эхлээд жил болгон ердийн үед хомсдол үүсчихдэг газрын тосны бүтээгдэхүүний. Энэ жил биднийг 100 хувь газрын тосны бүтээгдэхүүнээр хангаж байгаа Оросын Холбооны Улс өөрснөө хомсдолтой болчихлоо. Энэ бол бараг 2 сар үргэлжилнэ гэж би бодож байгаа юм. Тэгэхээр энэ хомсдол бол манай улсад ирнэ. Бидэнд ганцхан гарц байна шүү дээ. Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас газрын тосны бүтээгдэхүүн импортлох. Үнэ нь бол асар үнэтэй. Тэгэхээр яг өдийд бол манай дизель түлшний нөөц бүрдүүлэх, саяын цахилгаан станцын түүхий эд болох нүүрсний нөөцийг бүрдүүлэх асуудлыг яаралтай арга хэмжээ авч бүрдүүлэх нь зүйтэй гэсэн саналыг хэлэх байна.

Тэгээд энэ өвөл бол амжилттай давахыг Найдалаа сайдад амжилт хүсье.

Г.Тэмүүлэн: Эрчим хүчний сайд Найдлаа сайд бас анхаараарай. Гишүүдийн хэлж байгаа санал дээр. Тэгээд танд бас найдаж байна шүү гэж хэлж байна шүү Найдлаа сайд аа. Тэгээд Байнгын хороо бас энэ эрчим хүчний асуудал, эрчим хүчний аюулгүй байдалтай холбоотой асуудлыг өнгөрсөн жилийн 9 сард бас яг хэлэлцэж байсан. Ингээд шаардлагатай бол бид нар бас ээлжит бус Байнгын хорооны хурлыг хийгээд, тодорхой шийдвэр төслүүдийг гарахад бол бэлэн байгаа. Эрчим хүчний аюулгүй байдал, бензин, түлшний хангамжийн асуудлууд өөрөө чухал асуудлууд байгаа. Жангабыл гишүүнд бас баярлалаа.

Гишүүд үг хэлж дууслаа. Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалтад бэлтгэгцгээе. Санал хураалт. 56,3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жангабыл чуулганд илтгэнэ.

12.17 цаг.

3 дахь асуудалдаа орцгооё.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Уг хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна. Мэндсайхан сайдыг микрофонд урьж байна.

3.Мэндсайхан: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын 65 сая еврогийн “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг Улсын Их Хурлын Эдийн засаг, Төсөв болон Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороодоор 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хэлэлцэн дэмжиж, Ерөнхий сайдын захирамжаар гарын үсэг зурах эрх олгосны дагуу

“Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-т 2026 оны 06 сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан.

“Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд Хавдар судлалын үндэсний үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв, Улсын 1 дүгээр төв эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг, ДБЭТ зэрэг 7 байгууллагад нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах төслүүдийг хэрэгжүүлэхээр хэлэлцээрийн хавсралтад тусгасан болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу энэхүү санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр нь Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах олон улсын гэрээ тул “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр” соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Сангийн яамнаас ажлын хэсэг хэвээрээ түрүүн танилцуулсан байгаа. Батлан хамгаалах яамны Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга хурандаа Эрхэмбаярын Гансүх, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Насангийн Отгонбаяр, Эрүүл мэндийн сайд Батшугар, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Эрдэнэбаяр ирсэн байна. Тус яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Нямдэлгэрийн Хүрэлбаатар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Алдаржавхлан сайд. Соёл урлагийн бодлогын зохицуулалтын газрын дарга Наранцэцэг. ХСҮТ-ийн Ерөнхий захирал Цэлээжавын Батболд, ЭХЭМҮТ-ийн Ерөнхий захирал Жүгдэрийн Отгонбаатар, ГССҮТ-ийн захирал Эрдэнэцэцэгийн Галбадрах, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, хурандаа Төмөрсүхийн Нарантуяа, Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмч, хурандаа Болор-Эрдэнэ гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байгаа юм байна.

Энэхүү хэлэлцээрийн хуулийн төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд байна уу. Батшугар сайд.

Э.Батшугар: Эрхэм байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ер нь бол эрүүл мэндийн салбар болон Монгол Улсын иргэдийн нас баралтын шалтгааныг харахад бол номер нэгд нь зүрх судасны өвчин байдаг. 2-т нь хавдар, 3-д нь осол гэмтэл, гаднын шалтгаантай. Энэ 3 нийлэхээр ер нь 75 хувийг нь дангаараа эзэлж байгаа юм. Хавдартай холбоотойгоор бол маш чухал төсөл орж байгаа. Энэ бол 1 дүгээрт PET scan гэж байгаа юм. PET scan бол хавдрыг илрүүлдэг, заавал зүсэлт хийхгүйгээр, эд эсийн шинжилгээ хийхгүйгээр илрүүлдэг тийм төхөөрөмж. Цаашлаад яривал энэ бол хавдраа авхуулаад, химийн эмчилгээ болон туяа эмчилгээнд орсны дараа нь хавдар нь ахиж нөгөө бие эрхтэнд нь эс нь байна уу, үгүй юу бас тогтоодог.

Хавдрын эмнэлэгт одоогоор бол PET scan байхгүй байгаа юм. Тэгэхээр ямар нөхцөл байдал үүсэж байна вэ гэхээр хажууд байгаа хувийн эмнэлэг рүү очоод, тэгээд 3 сая төгрөгийг карманаасаа гаргаад, тэгээд PET scan шинжилгээ өгдөг. Жилдээ бол 8 мянган иргэн хавдрын онош тогтоогддог. Тэгэхээр бол хавдар судлалын төв энэ PET scan болсноор иргэдийн карманаас 24 тэрбум төгрөг хэмнэнэ. Цаашлаад энэ нейротрансммиттер гэж тархины гүнд байдаг хагалгааны төхөөрөмжтэй болж байгаа юм. Энэ нь бол гавлыг нь цоолоод, миллиметрийн алдаагүйгээр тэр

хавдрыг авах энэ эмчилгээ Монгол Улсад нэвтэрснээр дор хаяж 40 тэрбум төгрөгийн гадагшаа явах урсгал хэмнэгдэнэ. Тэгэхээр энэ 2 дангаараа харахад бол бараг 64 тэрбум төгрөг хэмнэгдэх юм.

Мөн цаашлаад яривал Монгол Улсад өнөөдөр эмчлэгддэггүй 25 өвчний онош байдаг. Тэгэхээр энэ нь 1-ээр багасаад, 24 болно. Тэгэхээр энэ маш чухал төхөөрөмж болон санхүүжилт авах гэж байгаа юм гэж хэлье.

Цаашлаад яривал бид нар Их Хурлын гишүүд Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль баталсан энэ парламентаар. Энэ бол Монгол Улсад анхдагч хууль болон маш чухал хууль. Үүнтэй холбоотой энэ хуулийг яг амьдруулахын тулд бас 1 дүгээр эмнэлэгт орж байгаа энэ санхүүжилт маш чухал шүү гэж хэлмээр байна гишүүддээ.

Эх нялхсын хувьд бол бас тодорхой хэмжээний бас чадавхыг нь сайжруулж байгаа. Ялангуяа нярайн хагалгааны төхөөрөмжүүдийг авч байгаа. Яг үнэнийг хэлэхэд өдөр болгон л ээж, аав нар над дээр байнга ирж, манай хүүхэд өвдсөн байна. Эх нялхас дээр эмчлэхгүй байна гэсэн тийм зүйл яригддаг. Тэгэхээр энийг хийснээр бид нар бас хүүхдүүдийнхээ эндэлтийг багасгах боломж үүсэж байгаа шүү. Тийм бол эрхэм гишүүд энэ төслийг дэмжиж өгнө үү гэж хэлмээр байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батшугар сайдад баярлалаа. Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Энэхүү хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлтгэцгээе. Санал хураалтыг явуулъя. 56,3 хувиар дэмжигдлээ.

Чуулганы хуралдаанд уг асуудлыг Анар гишүүн танилцуулах уу. Энхнасан гишүүн танилцуулъя.

Эрүүл мэндийн яамныханд, Батшугар сайдад, бас эмнэлгийн дарга нарт ажлын амжилт хүсье. Нийт 65 сая долларын төслийг, зээлийн хэлэлцээрийг бид нар авахаар соёрхон баталж байна. Байнгын хороогоор. Тэгээд үндсэндээ энэ хавдартай холбоотой, гэмтэл согогтой холбоотой, эх, хүүхэд, нярайн эндэгдэлтэй холбоотой, эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулахтай холбоотой эмнэлэг бүрд ямар ч байсан ингээд ойролцоогоор 10 орчим сая долларын бас төсөл хэрэгжинэ. Тэгээд ойролцоогоор бол 30-35 тэрбум төгрөгийн төслийг хэрэгжүүлэх нь байна. Та бүхэн маань бас амжилттай хэрэгжүүлээрэй. Тэгээд та бүхний ажилд өндөр амжилтыг хүсье. Баярлалаа.

Гишүүддээ баярлалаа. Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан байна. Хуралдаан хаасныг мэдэгдье.

12.24 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ